

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	4
2	Аудитын тайлан	6
2.1.	Оршил.....	6
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	6
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	7
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	7
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	8
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	9
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	9
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	10
2.8.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	10
2.8.2	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	11
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	13
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	13
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	13
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	13
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	14
3	Менежментийн захидал.....	15
3.1	Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал.....	15
3.1.1	Илрүүлэлт:	15
3.1.2	Эрсдэл:	15
3.1.3	Өгсөн зөвлөмж:	15
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	16
3.2	Жижиг мөнгөн сантай холбоотой асуудал.....	16
3.2.1	Илрүүлэлт:	16
3.2.2	Эрсдэл:	16
3.2.3	Өгсөн зөвлөмж:	16

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	16
3.3 НБББББ-тай асуудал	16
3.3.1 Илрүүлэлт:	16
3.3.2 Эрсдэл:	16
3.3.3 Өгсөн зөвлөмж:	16
3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	16
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан	18
4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	18
4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	21
4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	23
4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	25
5 Хавсралт	

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УБДС ТӨХК	Улаанбаатар дулааны сүлжээ төрийн өмчит хувьцаат компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

“ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА,
ТУРШИЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛ, БИЗНЕСИЙН
КОРПОРАЦИ” ТӨААТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
П.НАСАНЖАРГАЛ ТАНАА

2019.03.15 № 06/444
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци” ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалтай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци” ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Үндсэн хөрөнгө бодитой оршин байхгүй, авлага барагдуулаагүй, түрээсийн орлогын 30 хувийг улсын төсөвт төвлөрүүлээгүй зэрэг нийт 85,8 сая төгрөгийн материаллаг алдаа, зөрчил нь санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал” ,” Иж бүрэн байх “гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч П.Насанжаргал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дүгээр сарын 25-наас 2019 оны 3 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн

баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Пийк Ом Аудит ХХК-ний аудитор З.Цэцэгээ хариуцаж хэрэгжүүлэв.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 19/15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн ирээдүйн хөгжлийн чиг хандлагын технологийн болон бизнес загварчлалын талаар судалгаа хийж яам, салбарын холбоо, аж үйлдвэрийн паркттай хамтран ажиллах, Шинжлэх ухаан, технологийн болон инновацийн төслүүдийг хэрэгжүүлэх, өөрийн шинжлэх ухааны чадавхийг нэмэгдүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн Б/161 тоот тушаалаар баталсан дүрмэнд Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Малын гаралтай түүхий эдийг үнэ цэнэтэй бүтээгдэхүүн болгон боловсруулж гадаад дотоодын зах зээл дээр гаргах үндэсний оюуны чадавхийг хөгжүүлэх.
- Хөнгөн үйлдвэрийн салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, туршилт, зохион бүтээх ажил, зөвлөх үйлчилгээг үзүүлэх, сургалт, үйлдвэрлэл, инновацийн үйл ажиллагааг үр ашигтай явуулах.
- Шинжлэх ухаан болон үйлдвэрлэл технологийн паркийг хөгжүүлэх ажилд оролцох
- Салбарын тулгамдсан асуудлаар эрдэм шинжилгээний бага хурал, семинар зохион байгуулах
- Хөнгөн үйлдвэрийн салбарт төрөөс баримтлах бодлого, стратеги боловсруулахад мэргэжлийн байгууллагын зүгээс санал боловсруулж оролцох

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
 - Шилэн дансны тухай хууль
 - Шинжлэх ухаан, технологийн тухай хууль
 - Технологи дамжуулах тухай хууль
 - Инновацийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг

алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна. Үүнд:

2016 онд Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын гүйцэтгэх захирлын тушаалаар батлан мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалын дагуу холбогдох өөрчлөлтийг тусгаагүй байна.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “covor soft” програм хангамж ашигладаг байна.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлыг сонгов.

Энэ нь төслөөс орсон санхүүжилтийн зардал нь төслийн хугацаа дуустал урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэдэгтэй холбоотой юм.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын 2018 оны мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлын дүн 316,0 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 6,3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулав.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь төлөвлөлтийн үед эрсдлийг дунд гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 5 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Шинжлэх ухаан паркийн захиргаа, шинжлэх ухаан технологи, үйлдвэрлэлийн нэгдлээс эвлэрлийн гэрээгээр авах 26,4 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй байсныг аудитын явцад залруулав.
- УБДС ТӨХК-аас халаалтын цогц төхөөрөмжийг 2012 онд 20 жилийн хугацаатай зээлээр авсантай холбоотой өглөгийг дансны өглөг дансаар бүртгэсэн байсан

34,2 сая төгрөгийг богино болон урт хугацаат бусад өр төлбөр дансанд тусгуулж аудитын явцад залруулга хийлгэв.

- Мөнгөн гүйлгээний тайлан дах зарлагын ангилал 13,9 сая төгрөгөөр буруу илэрхийлэгдсэнийг аудитын явцад залруулга хийлгэв.
- Бараа материалын ангиллыг 1,6 сая төгрөгөөр буруу бүртгэснийг аудитын явцад залруулав:
- Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бичилт 6,436,4 сая төгрөгөөр буруу илэрхийлэгдсэн байсныг аудитын явцад залруулга хийлгэв.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	1.1	
2	Албан шаардлага өгсөн	4	90.9	
3	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	1	3.6	
	Дүн	8	94.5	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: Үндсэн хөрөнгийн талаар

2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгийн дансанд биетээр оршин байхгүй байсан 3,6 сая төгрөгийн модон байшинг олж аван, холбогдох арга хэмжээ авч шийдвэрлүүлэх гэсэн албан шаардлага өгсөнийг хэрэгжүүлээгүйгээс одоог хүртэл бэлнээр тоолж бүртгэж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-т “ Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн

эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдэл: Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлэх

Асуудал 2: Авлага

2016 онд түрээсийн тооцооноос үүссэн Бизнес инкубатор төвөөс 3,3 сая төгрөг, Вүүд блаинд ХХК-аас 1,5 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1-д “ Төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө эсхүл дээд шатныхаа төсвийн талаар харицлага хүлээдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдэл:

Авлага барагдуулах ажлыг зохион байгуулж, хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх

Асуудал 3: Бараа материал

Бараа материалын тооллогын бүртгэл бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлээс 0,2 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдэл:

Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх

Асуудал 4: Орлогын талаар

Тайлант онд төрийн өмчийг хуулийн этгээд, иргэнд түрээслүүлсэнээр түрээсийн орлого 286,5 сая төгрөг олсоноос ашиглалтын зардалд 55,6 сая төгрөг, цалингийн зардалд 168,5 сая төгрөгийг тус тус төлж тайлант онд 71,0 сая төгрөгийн алдагдалтай ажилласнаас түрээсийн орлогын улсын төсөвт төвлөрүүлэх 85,9 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байгаа нь ТӨБЗГ-ын 2016 оны 402 дугаар тогтоолын 2-т “ Улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хэмжээг түрээсийн нийт орлогын 30 хувиар тогтоож 2017 оны 1 сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй” гэж заасантай нийцээгүй байна.

Шийдэл:

Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх

Асуудал 5: Шилэн дансны талаар

Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь шилэн дансны бие даасан цэгтэй байх гэсэн заалтыг мөрдөөгүйгээс тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүргээ биелүүлээгүй байна.

Шийдэл:

Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

- Өөрийн үйл ажиллагааны орлогоо нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллах.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Тус ТӨҮГ нь 2018 оны бизнес төлөвлөгөөгөөр тайлант оны орлогыг 338,7 сая төгрөгөөр, үйл ажиллагааны зардлыг 398,8 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Тайлант онд орлогын гүйцэтгэл 323,7 сая төгрөг, зардлын нийт гүйцэтгэл 350,7 сая төгрөг байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансаар мэдээлэл огт оруулаагүй байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 66.7 хувьтай байна.

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг ашиглаж байна. Цаашид ашиглах хөрөнгүүдийг дахин үнэлэх, ашиглагдах боломжгүй хөрөнгүүдийг зохих зөвшөөрлийг дагуу дансаас хасах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилаагүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБООС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд нийт 1,1 сая төгрөгийн ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй, шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т *“Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө.”* гэж заасныг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Хууль тогтоомж зөрчигдөх, тайлант жилийн зардал бодитоор илэрхийлэгдэхгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаалыг мөрдөж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллана.

3.2 Жижиг мөнгөн сантай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Иргэн болон хуулийн этгээдээс түрээсийн орлогыг бэлэн, бэлэн бусаар төвлөрүүлдэг боловч бэлэн мөнгөний үлдэгдэлийг сар бүр тоолж, тооцоог бодоогүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Хөрөнгө мөнгө дутагдах, залилан үүсэх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Сар бүр касс дах бэлэн мөнгөний тооллого хийж, тооцоог бодож байх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллана.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримттай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2016 онд боловсруулан мөрдөж байгаа бөгөөд тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй, заавар, журмын шинэчлэлт, өөрчлөлтийг хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн бичилтүүд, холбогдох стандарт, журмыг зөрчсөнөөс нягтлан бодох бүртгэл алдаатай бүртгэгдэх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг бичиг баримтыг өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	1/1/2018	12/31/2018
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,459,300.10	3,780,857.21
1.1.2	Дансны авлага	12,813,670.00	50,755,704.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	
1.1.6	Бараа материал	7,934,263.18	2,878,020.55
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	83,455,542.01	142,053,759.15
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	106,662,775.29	199,468,340.91
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,148,189,098.32	7,106,248,377.63
1.2.2	Биет бус хөрөнгө	882,486.61	137,472,832.56
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,149,071,584.93	7,243,721,210.19
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,255,734,360.22	7,443,189,551.10
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	33,576,474.78	1,635,794.97
2.1.1.2	Цалингийн өглөг	-	
2.1.1.3	Татварын өр	58,376,163.84	71,533,443.67
2.1.1.4	НДШ-ийн өглөг	1,391,167.64	1,591,000.00
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг	-	4,558,375.40
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	141,322,500.00	210,870,000.00
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		2,198,144.72
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	234,666,306.26	292,386,758.76
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		27,476,793.53
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	27,476,793.53
2.2	Өр төлбөрийн нийт дүн	234,666,306.26	319,863,552.29
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	122,037,243.10	258,725,643.10
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	307,921,881.30	307,921,881.30
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,669,218,270.00	7,710,365,712.49
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	100,931,461.00	100,931,461.00

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын 2018 оны
санхүүгийн тайлангийн аудит

2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,179,040,801.44)	(1,254,618,699.08)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,021,068,053.96	7,123,325,998.81
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,255,734,360.22	7,443,189,551.10

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	18,963,809.11	20,290,375.00
2	Борлуулалтын өртөг		2,058,910.34
3	Нийт ашиг(алдагдал)	18,963,809.11	18,231,464.66
4	Түрээсийн орлого	230,665,802.56	260,470,452.12
5	Хүүгийн орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	22,098,895.00	
9	Борлуулалт, маркетингийн зардал		4,627,110.92
10	Ерөнхий ба удирдлагын зардал	251,180,054.15	341,332,989.28
11	Санхүүгийн зардал	84,979,691.74	
12	Бусад зардал	45,995,203.05	3,761,338.82
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-110,426,442.27	-71,019,522.24
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-110,426,442.27	-71,019,522.24
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-110,426,442.27	-71,019,522.24
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын 2018 оны
санхүүгийн тайлангийн аудит

24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	эмж төлөгдсөн капитал	ӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ нэмэгдэл	Гадаад валютын үерлэлтийн нөлөө	ҮЙН ӨМЧИЙН бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	122,037,243.10		307,921,881.3	1,669,218,270.0		100,931,461	1,068,614,359.17	1,131,494,496.23
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
3	Залруулсан үлдэгдэл								
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)							-110,426,442.17	-110,426,442.17
5	Бусад дэлгэрэнгүй орлого								
6	Өмчид гарсан өөрчлөлт								
7	Зарласан ногдол ашиг								
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
9	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	122,037,243.10		307,921,881.3	1,669,218,270.0		100,931,461	-1,179,040,801.44	1,021,068,053.96
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
11	Залруулсан үлдэгдэл								
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							-71,019,522.24	-71,019,522.24

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпорацн ТӨААТҮГ-ын 2018 оны
санхүүгийн тайлангийн аудит

13	Бусад дэлгэрэнгүй орлого							
14	Өмчид гарсан өөрчлөлт							
15	Зарласан ногдол ашиг							
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	136,688,400.00		6,041,147,442.5				6,177,835,842.49
17	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	258,725,643.10	307,921,881.3	7,710,365,712.5	100,931,461	-1,254,618,699.08		7,123,325,998.81

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	343,478,429.67	317,350,429.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	18,963,809.11	4,595,373.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	22,098,895.00	
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,202,423.00	
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	69,547,500.00	69,547,500.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	230,665,802.56	243,207,556.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	345,592,363.95	312,974,891.89
1.2.1	Ажиллагчдад төлсөн	142,549,459.20	132,580,510.20
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	36,589,326.00	36,874,392.09
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	40,986,161.25	22,480,641.44
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	62,050,272.62	55,680,134.73
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,856,693.80	3,525,400.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	29,459,252.11	30,344,397.16
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	115,830.00	115,830.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	31,985,368.97	31,373,586.27
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,113,934.28)	4,375,537.11
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,898,282.00	225,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(6,898,282.00)	(225,000.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		2,828,980.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(2,828,980.00)
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(9,012,216.28)	1,321,557.11
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,471,516.38	2,459,300.10
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,459,300.10	3,780,857.21

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	2019-03-14	Аудитын нэр	Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
Шалгалдсан байгууллагын нэр:	Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпорацн ТӨААТҮГ			САГ-2019/73/СТА/ТӨҮГ
				Сая төгрөгөөр

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгө н дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5			9	10
1	Мөнгөн хөрөнгө		Түрээсийн орлогын бэлэн бэлэн бусаар төвлөрүүлдэг тайлант онд бэлэн мөнгөний үлдэгдэлийг тоолж баталгаажуулдаггүй байна.		Зөвлөмж	2019.03.14.		Гүйцэтгэх захирлыг үүрэг гүйцэтгэгч Нягтлан бодогч	П.Насанжаргал Ц.Ичинхорлоо
2	Балансын данстай холбоотой асуудал		2016 онд үүссэн 2 харилцагийн авлагыг барагдуулаагүй байна.	4.8	Албан шаардлага	2019.03.14.		Гүйцэтгэх захирлыг үүрэг гүйцэтгэгч Нягтлан бодогч	П.Насанжаргал Ц.Ичинхорлоо
3	Балансын данстай холбоотой асуудал		Бараа материалын тооллогын бүртгэл бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлээс зөрүүтэй	0.2	Албан шаардлага	2019.03.14.		Гүйцэтгэх захирлыг үүрэг гүйцэтгэгч Нягтлан бодогч	П.Насанжаргал Ц.Ичинхорлоо
4	Өмнөх аудитын зөвлөмжтэй холбоотой		Түрээсийн орлогын 30 хувийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.	85.9	Албан шаардлага	2019.03.14.		Гүйцэтгэх захирлыг үүрэг гүйцэтгэгч Нягтлан бодогч	П.Насанжаргал Ц.Ичинхорлоо
5	Өмнөх аудитын зөвлөмжтэй холбоотой		Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2 ширхэг модон барилга бодитоор оршин байхгүй зөрчлийн арилгах талаар 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	3.6	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлэх	2019.03.14.		Гүйцэтгэх захирлыг үүрэг гүйцэтгэгч Нягтлан бодогч	П.Насанжаргал Ц.Ичинхорлоо

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпорацн ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

6	Байгууллагын үйл ажиллагаа тай холбоотой		Шилэн дансын мэдээллийг оруулаагүй байна		Албан шаардлага	2019.03.14.		Гүйцэтгэх захирлыг үүрэг гүйцэтгэгч Нягтлан бодогч	П.Насанжаргал Ц.Ичинхорлоо
7	НББ бодлогын баримт бичиг		2016 онд Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпорацн ТӨААТҮГ-ын гүйцэтгэх захирлын тушаалаар батлан мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалын дагуу холбогдох өөрчлөлтийг тусгаагүй байна		Зөвлөмж	2019.03.14.		Гүйцэтгэх захирлыг үүрэг гүйцэтгэгч Нягтлан бодогч	П.Насанжаргал Ц.Ичинхорлоо
8	Балансын данстай холбоотой асуудал		Тооцооны дансаар дамжуулаагүй шууд бараа материалын дансанд орлого авч тайлагнасан	1.1	Зөвлөмж	2019.03.14.		Гүйцэтгэх захирлыг үүрэг гүйцэтгэгч Нягтлан бодогч	П.Насанжаргал Ц.Ичинхорлоо
	Нийт дүн			95.6					